

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн аудитын шийдлийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /төг/	Аудитын шийдлийн утга	Биелэлт ирүүлэх огноо	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Биелэлт
1	Зөвлөмж	Ландфиллийн талбайн үлчилээний барилга байгууламжийг НҮБ-ийн буцалтгүй тусламжаар хийгдэж тус байгууллагад хүлээлгэн өгсөн ч өнөөдрийг хүртэл ашиглахгүй, ашиглах боломжгүй болсон, тээврийн хэрэгсэл шатсан, мөргөлдсөн шалтгаанаар цашид ашиглах боломжгүй болсон ч холбогдох газарт асуудлыг уламжлан шийдвэрлүүлээгүй.	0	Хөрөнгийн асуудлыг НӨХГ-т уламжлан шийдвэрлүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	8/30/2024	Ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж Нийслэлийн өмчийн харилцааны газарт албан бичгээр хүргүүлэх.	Тооцооны нягтлан бодоч Ж.Мөнхзул	Тус газрын үндсэн хөрөнгийн данс бүртгэлд үнэ төлбөргүйгээр хүлээн авсан зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа үндсэн хөрөнгүүдийг НӨХГ, Хот байгуулалт, хотын стандартын газарт-т албан бичгээр хүсэлт хүргүүлсэн боловч тус барилга, байгууламж нь 2021 онд хүлээн авсан барилгын нэсжилт болоогүй шалтгаанаар дүгнэлт гаргах боломжгүй өөр зориулалтаар ашиглах чиглэл өгсөн байна. НӨХГ-т ашиглах хугацаа дууссан тээврийн хэрэгсэлүүдийг актлах саналыг хүргүүлж НЗД-ын 2024 оны 06 сарын 24-ны өдрийн А/757 тоот захирамжаар, НӨХГ-ын даргын 2024 оны 06 сарын 25 ны өдрийн А/128 дугаар тушаалаар шийдвэрлүүлэн ажиллаа. Мөн байгууллагын чиг үүрэг дүүрэгт шилжсэнтэй холбоотой үндсэн хөрөнгүүдийг НӨХГ-т уламжлан шийдвэрлүүдийг шат даараатайгаар гаргуулан ажиллаж байна.
2	Зөвлөмж	Авлагын үлдэгдлийг тулган шалгахад иргэн Байгальмаагаас Сити ОО түрээсийн 3,512.5 мянга, Эхлэх-Үүд ХХК-иас 17,917.5 мянган төгрөгийн авлага барагдаагүй хугацаа хэтэрсэн байна.	21,430,000	Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулж, шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах	8/30/2024	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хугацаа хэтэрсэн авлага барагдуулах албан бичиг хүргүүлэх	Тооцооны нягтлан бодоч Ж.Даариймаа	Иргэн Байгальмаагаас авах авлагыг 2023 онд Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгсөн боловч иргэний оршин суух хаяг өөрчлөгдсөн шалтгаанаар буцаж иргэний оршин суух хаягийн дагуу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгөхөөр материалыг бүрдүүлсэн уг шалтгаанаас тухайн шүүхийн шийдвэр гараагүй байна. Эхлэх-Үүд ХХК -иас авах шүүхийн шийдвэртэй авлагыг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тус авлагыг барагдуулах талаар хандахад тухайн байгууллагаас авах авлагыг шат даараатайгаар шийдвэрлэж байна гэсэн хариу өгсөн байна.

3	Албан шаардлага	Худалдан авалтын дүнгээс түүвэрлэн шалгахад Өгөөжит бор хайрхан ХХК-иар 34,588.2 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлдээ шууд гэрээ байгуулж худалдан авах ажиллагааны журмыг зөрчсөн байна.	34,588,200	Ажил гүйцэтгүүлдээ 34,588.2 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн зөрчлийг арилгах	8/30/2024	Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих	Эдийн засагч А.Хишигзул	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.
4	Зөвлөмж	Кассын баримтыг тулган шалгахад хичээлийн жилийн нээлтийг тохиолдуулан ажилчдын хүүхдүүдийг хүлээн авах арга хэмжээ зохион байгуулж 8,348.8 мянган төгрөгийг зарцуулсан	8,348,800	Кассаас зориулалт бусаар хөрөнгө зарцуулахгүй байх	8/30/2024	Кассан дахь мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавих	Тооцооны нягтлан бодогч Ж.Даариймаа	Тайланд онд эдгээр алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар кассын зарцуулалтын тайланд хяналт тавин ажиллаж байна.
5	Албан шаардлага	Тайлант онд албан томилолтын зардалд төсөв батлагдаагүй байхад 21,090.9 мянган төгрөг зарцуулсан байна.	21,090,900	Төсөв батлагдаагүй байхад томилолтын зардал гаргасан зөрчлийг арилгах	8/30/2024	Батлагдсан төсвийн хүрээнд гарч буй томилолтын зардалд хяналт тавин ажиллах	Ерөнхий нягтлан бодогч М.Оюунсүрэн	Батлагдсан төсвийн дагуу гарч байгаа зардлуудад хяналт тавин ажиллаж байна.
6	Зөвлөмж	Цалингийн тооцооллыг тулган шалгахад хувь хүний орлогын албан татварыг жилийн эцэст тооцоогүйгээс 4,317.3 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийн зөрүү үүсгэсэн байна.	4,317,300	Цалингаас суулгах ХХОАТ-н тооцооллыг үнэн зөв хийх	8/30/2024	Сар бүрийн цалингийн тооцооллыг тулган шалгаж баталгаажуулах	Тооцооны нягтлан бодогч Ж.Мөнхзул	Сар бүр цалингийн тооцооллыг тулган шалгаж баталгаажуулан ажиллаж байна.
7	Зөвлөмж	Тус газрын ашиг алдагдлыг харьцуулахад тайлант онд 3,837,791.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан ба зорилтот түвшинтэй харьцуулахад алдагдал 1,535,802.3 мянган төгрөгөөр өссөн, өмнөх онтой харьцуулахад 33,970.3 мянган төгрөгөөр буурсан байна.	0	Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж, алдагдлыг багасгах	8/30/2024	Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлд шинжилгээ хийх, үр дүнг удирдлагад таницуулах	Эдийн засагч А.Хишигзул	Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж, сар бүр шинжилгээ хийж үр дүнг удирдлагад танилцуулан ажиллаж байна.

8	Албан шаардлага	Тус газрын зарим чиг үүргийг дүүрэгт шилжүүлэхтэй холбоотой тайлангийн хурал хийж (500 ажилтан) үйлчилгээний ажилтнуудад 28,957.9 мянган төгрөгийн бэлэг олгосон.	28,957,900	Ажилтнуудад олгосон бэлэгийг зардалд 28,957.9 мянган төгрөг зарцуулсан зөрчлийг арилгах	8/30/2024	Батлагдсан төсвийн хурээнд гарч буй зардалд хяналт тавих	Ерөнхий нягтлан бодогч М. Оюунсүрэн	Тайланд онд эдгээр алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар зарцуулалтанд хяналт тавин ажиллаж байна.
9	Албан шаардлага	Аэр Маркет Холидэй ХХК-д 5,579.1 мянган төгрөгийн нислэгийн төлбөр шилжүүлсэн	5,579,100	Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг зөрчин хувийн агаарын тээвэрээр үйлчлүүлсэн зөрчлийг арилгах	8/30/2024	Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, гадаад томилолтын зардалд хяналт тавих	Ерөнхий нягтлан бодогч М. Оюунсүрэн	Тайланд онд эдгээр алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар зарцуулалтанд хяналт тавин ажиллаж байна.
10	Албан шаардлага	Байгууллага хамт олноо сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага болон тайлан дүрсжүүлэх ажлын хөлсөнд нийт 25,300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн	25,300,000	Байгууллага хамт олноо сурталчлах үйл ажиллагаанд 25,300.0 мянган төгрөг зарцуулсан зөрчлийг арилгах	8/30/2024	Зар сурталчилгааны зардалд хяналт тавих	Ерөнхий нягтлан бодогч М. Оюунсүрэн	Тайланд онд эдгээр алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхаар зарцуулалтанд хяналт тавин ажиллаж байна.
			149,612,200					

ХЯНАСАН:
 САНХҮҮ БҮРТГЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТЭСИЙН ДАРГА БӨГӨӨД
 ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
 М.ОЮУНСҮРЭН



БОЛОВСРУУЛСАН:
 ТООЦООНЫ НИЯГТЛАН БОДОГЧ
 Ж.ДААРИЙМАА